



МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 08 сарын 15 өдөр

Дугаар А/156.

Улаанбаатар хот

Ажлын байрны төлбөрөөс хөнгөлөх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 6.3.5, “Журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2015 оны 41 дүгээр тогтоолоор баталсан “Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам”-ын 3.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 01/2203, 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 01/2253, 01/2252, 2022 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 01/2323, 2022 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 01/2426, 01/2425, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2022 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн 10/4170, Эрчим хүчний яамны 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн в/2581, Барилга, хот байгуулалтын яамны 2022 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 3/3552 тоот албан бичгүүдээр ирүүлсэн санал, “Ажлын хэсэг байгуулах тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/105 дугаар тушаалаар байгуулсан Ажлын хэсгийн 2022 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн дүгнэлтийг тус тус үндэслэн хавсралтад заасан 9 аж ахуйн нэгж, байгууллагын нийт 30 гадаад ажилтаны ажлын байрны төлбөрийг 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл 50 хувиар хөнгөлсүгэй.

2. Хөнгөлөлтөд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын урьдчилж төлсөн 2022 оны ажлын байрны төлбөрийн зөрүүг дараагийн төлбөрт шилжүүлэн тооцох, буцаан олгох арга хэмжээ авахыг Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар /Л.Дашдэмбэрэл/-т даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /С.Дамбий/-т даалгасугай.

САЙД



А.АРИУНЗАЯА

151221766

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын
сайдын 2022 оны 08 сарын 15 өдрийн
1156 дугаар тушаалын хавсралт

**АЖЛЫН БАЙРНЫ ТӨЛБӨРӨӨС ХӨНГӨЛӨХ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА,
ҮЙЛ АЖИЛЛАГАА, ГАДААДЫН АЖИЛЛАХ ХҮЧ, МЭРГЭЖИЛТНИЙ ТОО**

№	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Гүйцэтгэх үйл ажиллагаа	Гадаадын ажиллах хүч, мэргэжилтн ий тоо	Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгосон эрх зүйн баримт бичиг	Асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал
Нэг. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулах					
1	“Туркиш Бэйкери Дэниз” ХХК	Нарийн боов үйлдвэрлэл, Худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх	1	“Гадаадаас 2022 онд авах ажиллах хүч, мэргэжилтний тухай” Засгийн газрын 2022 оны 231 дүгээр тогтоол	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2022 оны 07 дугаар сарын 08-ний өдрийн 01/2252 тоот албан бичиг
2	“Каппэ Бэнэ Монголиа” ХХК	Нийтийн хоолны үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх	1	“Гадаадаас 2022 онд авах ажиллах хүч, мэргэжилтний тухай” Засгийн газрын 2022 оны 231 дүгээр тогтоол	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 01/2253 тоот албан бичиг
3	“Агар тайж” ХХК	Ариун цэврийн цаасны үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх	2	“Гадаадаас 2022 онд авах ажиллах хүч, мэргэжилтний тухай” Засгийн газрын 2022 оны 231 дүгээр тогтоол	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 01/2203 тоот албан бичиг
4	“Эм Жи Эл Акуа” ХХК	Цэвэр усны үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх	3	“Гадаадаас 2022 онд авах ажиллах хүч, мэргэжилтний тухай” Засгийн газрын 2022 оны 231 дүгээр тогтоол	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2022 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 01/2323 тоот албан бичиг

5	“Нью Панда” ХХК	Ресторан, нийтийн хоолны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх	8	“Гадаадаас 2022 онд авах ажиллах хүч, мэргэжилтний тухай” Засгийн газрын 2022 оны 231 дүгээр тогтоол	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2022 оны 08 дугаар сарын 03-ний өдрийн 01/2425 тоот албан бичиг
6	“Ньюбулл” ХХК	Нийтийн хоолны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх	3	“Гадаадаас 2022 онд авах ажиллах хүч, мэргэжилтний тухай” Засгийн газрын 2022 оны 231 дүгээр тогтоол	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2022 оны 08 дугаар сарын 03-ний өдрийн 01/2426 тоот албан бичиг
Нийт			18		
Хоёр. Барилгын салбарт үйл ажиллагаа явуулах					
7	“Энэргүн констракшн” ХХК	Барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх	8	“Гадаадаас 2022 онд авах ажиллах хүч, мэргэжилтний тухай” Засгийн газрын 2022 оны 231 дүгээр тогтоол	Барилга, хот байгуулалтын яамны 2022 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 3/3552 тоот албан бичиг
Нийт			8		
Гурав. Эрчим хүчний салбарт үйл ажиллагаа явуулах					
8	“Кёосера Коммюникейшн Системс” ХХК	“Эрчим хүчний төсөл-2”-ийн хүрээнд Ховд аймагт 10МВт-ын хүчин чадалтай нарны цахилгаан станц барих	3	“Гадаадаас 2022 онд авах ажиллах хүч, мэргэжилтний тухай” Засгийн газрын 2022 оны 231 дүгээр тогтоол	Эрчим хүчний яамны 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн в/2581 тоот албан бичиг
Нийт			3		
Дөрөв. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулах					
9	“Кемпински Хаан Палас” ХХК	Зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх	1	“Гадаадаас 2022 онд авах ажиллах хүч, мэргэжилтний тухай” Засгийн	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2022 оны 07 дугаар сарын

			газрын 2022 оны 231 дүгээр тогтоол	29-ний өдрийн 10/4170 тоот албан бичиг
	Нийт			1
	НИЙТ			30

---oOo---